



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 134

Мандалговь

Хөрөнгөд үнэлгээ тогтоож, худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.4.1. дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:


Нэг: Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн түргэн тусламжийн дуудлагад ашиглагдаж байсан, 2000 онд үйлдвэрлэгдсэн УАЗ-469 маркийн 22-90 УБР улсын дугаартай автомашиныг 1,500,000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгөөр үнэлж нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 11 сарын 23-ны өдрийн 153 дугаар тогтоолын биелэлт хангагдаагүй тул 153 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Гурав: Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1. Эд хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ